



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/28

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалт, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Х.Доржханд), Эмнэлгийн тусламжийн хэлтсийн Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн (О.Энх-Уянга) нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Д.Наранмичид)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.МЭНДБАЯР

Эрүүл мэндийн газрын
даргын 2023 оны 11 дүгээр сарын
24 өдрийн 4/2 тоот тушаалын
хавсралт

**Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын нэрс**

№	Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа	Хүчинтэй хугацаа
1	Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Монос Хэнтий" ХХК- ийн 2-р эмийн сан	5 жил	2023.12.04 - 2028.12.04
2	Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Туушин тал" ХХК- ийн "Оргил" эмийн сан	5 жил	2023.11.25 - 2028.11.25
3	Дархан суманд үйл ажиллагаа явуулж буй "Мөнхбилэг Мөнх" ХХК-ийн эмийн сан	5 жил	2023.12.13 - 2028.12.13
4	Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Оточ Гурван Эрдэнэ" ХХК-ийн "Хөх гүн" эрэгтэйчүүд, нярайн үүдэн эмнэлэг	5 жил	2023.12.13 - 2028.12.13